

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/07/СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг: Утас:261668 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас:261885 Цахим хаяг:gunjidmaag@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Сэржмядаг Утас:260512 Цахим хаяг:serjmyadagb@audit.gov.mn Аудитор: А.Даваадорж Утас:260512 Цахим хаяг:davaadorja@audit.gov.mn Аудитор: Г.Мөнхчимэг Утас:260512 Цахим хаяг:munkhchimegg@audit.gov.mn Аудитор: Ч.Дашдаваа Утас:260512 Цахим хаяг:dashdavaach@audit.gov.mn Гэрээт ажилтан Т.Болормаа Гэрээт ажилтан Н.Нямсүрэн</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.3 Авлага.....	9
2.8.4 Урьдчилгаа	10
2.8.5 БАРАА МАТЕРИАЛ.....	12
2.8.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	13
2.8.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт	14
2.8.8 Үндсэн хөрөнгө	15
2.8.9 Өр төлбөр	16
2.8.10 Засгийн газрын хувь оролцоо.....	19
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	20
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	22
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	25
2.11. Шилэн дансны мэдээлэл	26
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	26
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	26
3. Менежментийн захидал.....	27
3.1 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал	27
3.2 Дамжуулан зээлтэй холбоотой асуудал	27
3.3 Төсөл хөтөлбөрийн нэгжтэй холбоотой асуудал.....	28
3.4 Харьяа газруудын илэрсэн зөрчилтэй холбоотой асуудал.....	29
Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	29
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	30
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	31
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	32
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	33
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	34
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	34
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБХОБ	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк
ОУХОБ	Олон Улсын хөрөнгө оруулалтын банк
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
МХБ	Монголын хөрөнгийн бирж
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
АТТҮЦК	Арилжааны төлбөр тооцоо үнэт цаасны компани
ЗГНС	Засгийн газрын нөөц сан
БСХС	Бичил санхүүгийн хөгжлийн сан
ААН	Аж ахуйн нэгж
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
МУНТГ	Монгол Улсын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ГЕГ	Гаалийн ерөнхий газар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

20 20. 05. 05 № 1486
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-т заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сангийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 11-2/2444 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2020 оны 5 дугаар сарын 5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 5 дугаар сарын 5-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж, Г.Мөнхчимэг, Ч.Дашдаваа, гэрээт ажилтан Т.Болормаа, Н.Нямсүрэн нар гүйцэтгэв.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сангийн яам нь үйл ажиллагааны зорилгоо “Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл :

- Санхүү, төсвийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Санхүүгийн салбарын зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах;
- Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;
- Гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсронгуй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод хяналтын бодлого, удирдлагаар хангах;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах;
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг зарим хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглах салбарын онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт сул байх үр дагавартай байна.

Сангийн яамны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар 2019 онд харьяа 27 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 124 зөвлөмж, 353,866.3 сая төгрөгийн 26 акт, албан шаардлага, 334,418.4 сая төгрөгийн 7 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, арга хэмжээ авч ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сангийн яамны бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 13 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 8,926,714.2 сая төгрөгийн 2 хувь буюу 178,534.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд Сангийн яамны 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 11-2/2444 дугаар албан бичгээр ирүүлсэн 2019 санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 11,421,261.1 сая төгрөгийн 2 хувь буюу 228,425.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

Аудит хийгдэх хугацаанд нийт хөрөнгийн дүн 103,805.0 сая төгрөгөөр нэмэгдэж залруулга хийгдсэн. Бидний хийсэн залруулга нь материаллаг байдалд тоон болон шинж чанарын хувьд нөлөөлөл үзүүлэхгүй тул материаллаг байдлын суурь үзүүлэлтийг дахин өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,182,532.1 сая, эцсийн үлдэгдэл 1,782,740.8 сая төгрөг болж, 345,791.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/ Бууралт-
Касст байгаа бэлэн мөнгө	44,704.6	57,443.1	12,738.5
Банканд байгаа бэлэн мөнгө	1,773,854.6	1,522,289.1	-251,565.5
Замд яваа мөнгөн хөрөнгө			0.0
Хадгаламж	309,972.9	203,008.6	-106,964.3
Дүн	2,128,532.1	1,782,740.8	-345,791.3
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0

Төсөвт байгууллага	93,795.9	159,983.3	66,187.4
Төсөл/сан	450,219.3	758,269.9	308,050.6
Төрийн сан			0.0
ТӨҮГ	1,584,516.9	864,487.6	-720,029.3
Дүн	2,128,532.1	1,782,740.8	-345,791.3

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 1,522,289.1 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 347,256.1 сая төгрөг байна. Үүнээс 36,126.2 сая төгрөг төсөвт байгууллагын, 606,539.5 сая төгрөг төрийн өмчит байгууллагын, 663,510.7 сая төгрөг тусгай сангийн, 216,112.7 сая төгрөг төсөл, хөтөлбөрийн үлдэгдэл байна.

Нийт 203,008.6 сая төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл байна. Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн банк Засгийн газрын тогтоолоор дотоодын банкнуудад 129,081.3 сая, гадаадын банкнуудад 16,413.7 сая, нийт 145,495.0 сая төгрөгийн хадгаламж байршуулсан;
- Төрийн банк Монголбанканд заавал байршуулах бэлэн мөнгөний нөөцийн үнэ цэний бууралтын санг хадгаламж хэлбэрээр өөртөө байршуулсан 55,013.6 сая төгрөг;
- Бичил санхүүгийн хөгжлийн сан 2,500.0 сая төгрөгийн хадгаламжийг холбогдох шийдвэргүйгээр Төрийн банканд байршуулсныг Монголбанкны шийдвэрээр 2020 онд улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт: Татварын ерөнхий газарт мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 61.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа 5.1 сая төгрөгийг өглөгөөр бүртгээгүй,
- И-баримтгүй болон зөрүүтэй дүнтэй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан /Чингэлтэй, Сонгинохайрхан, Багахангай 21.9 сая, Төв аймаг 26.0 сая төгрөг/
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар 8.5 сая төгрөгийн ажил гүйлгээг хийсэн. /Хан-Уул 0.9 сая, Нийслэл 0.8 сая, Чингэлтэй 0.1 сая, Сонгинохайрхан 3.1 сая, Сүхбаатар 0.6 сая, Налайх 2.6 сая, Багахангай 0.3 сая төгрөг/

Харьяа ТӨААН-үүдэд мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд: **Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв** нь гадаад, дотоод томилолтын зардалд анхан шатны бүрдэл дутуу баримтаар 7.2 сая, и-баримтаар баталгаажаагүй 2.0 сая, хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй 1.8 сая төгрөг зарцуулсан;

Үндэсний давхар даатгал ХК нь ажилтнуудын цагийн бүртгэлийг нягтлан бодогч хөтөлж, цалинг тооцож боддог, хамтын эрсдэлийн сангийн нөөцөд хамаарах хадгаламжийн дансанд байршуулсан мөнгөн сангийн хүүгийн орлого 194.2 сая төгрөгийг бусад орлогоор хүлээн зөвшөөрч, татвар төлөх үүргийг даатгалын компаниудад шилжүүлэхээр дотоод журамдаа заасан нь ААНОАТ-ын тухай хуульд заасан суутгагчийн үүргийг өөр этгээдэд шилжүүлсэн нь тухайн татварыг шилжүүлж авсан этгээд нь татварыг төлсөн эсэхээс үл хамаараад татварын өр төлбөр үүсэх эрсдэлтэй байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 529,812.9 сая, эцсийн үлдэгдэл 728,105.1 сая төгрөг болж, 198,292.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/ Бууралт-
Үнэт цаас	529,812.9	728,105.1	198,292.2
Дүн	529,812.9	728,105.1	198,292.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
ТӨҮГ	529,812.9	728,105.1	198,292.2

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн банк ХХК-ийн богино хугацаат үнэт цаас оны эцэст 728,104.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба тайлант онд Монголбанкны 3 хүртэлх сарын хугацаатай 226,686.9 сая төгрөгийн үнэт цаас худалдан авснаар нэмэгдэж, Монгол Улсын Хөгжлийн банк 28,394.7 сая төгрөгийн үнэт цаасыг буцаан худалдсанаас хасагдсан байна. Мөн Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн эзэмшиж байгаа 1.0 сая төгрөгийн Засгийн газрын бонд бүртгэлтэй байна.

2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,478,164.8 сая, эцсийн үлдэгдэл 1,668,131.3 сая төгрөг болж, 189,966.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Ажиллагчидтай холбогдсон авлага	29.3	64.2	34.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	2,067.3	12,068.6	10,001.3
Татаас, санхүүжилтийн авлага	22.2	13,472.4	13,450.2
Зээлийн хүүгийн авлага	204,995.0	196,950.0	(8,045.0)
Дансны авлага /ТӨҮГ/	322,006.8	800,807.5	478,800.7
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	31,789.3	25,206.8	(6,582.5)
Бусад авлага	143,765.3	276,334.7	132,569.4
Байгууллагаас авах авлага	142,196.5	275,574.4	133,377.9
Хувь хүмүүсээс авах авлага	1,568.9	760.3	(808.6)
Зээлийн авлага	773,489.6	343,227.1	(430,262.5)
Дүн	1,478,164.8	1,668,131.3	189,966.5
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	205,278.8	227,749.8	22,471.0
Төсөл/сан	31,025.6	118,289.7	87,264.1
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,241,860.4	1,322,091.8	80,231.4
Дүн	1,478,164.8	1,668,131.3	189,966.5

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын өсөлт нь Монгол Улсын Хөгжлийн банкны своп арилжааны авлага болон бусад авлага 85,809.7 сая төгрөг, Ирээдүйн өв сангийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/-ийн хуваарилалтаас авах өмнөх оны 87,196.5 сая төгрөгийн авлагатай холбоотой байна.

Нийт авлагын 1,211,401.5 сая төгрөг буюу 72.6 хувийг Монгол Улсын Хөгжлийн банк, 216,830.1 сая төгрөг буюу 13.0 хувийг Хадгаламжийн даатгалын корпорац, Зээлийн батлан даалтын сан, Төрийн банк ХХК болон тусгай сангууд, 223,975.9 сая төгрөг буюу 13.4 хувийг төсөл, хөтөлбөрүүдийн дамжуулан зээлийн авлага, 15,951.7 сая төгрөг буюу 0.9 хувийг харьяа 54 байгууллагуудын авлага эзэлж байна.

Төлбөртэй үйлчилгээний 12,068.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд дараах байгууллагын авлага байна. Тухайлбал:

- Хадгаламжийн даатгалын корпорацын шүүхэд шилжүүлсэн банкнуудаас авах хураамжийн 1,922.7 сая төгрөг;
- Зээлийн батлан даалтын сангийн төслөөс авах батлан даалт гаргах санхүүжилтийн авлага 10,130.1 сая төгрөгийн авлага байна.

Дансны авлага 800,807.5 сая төгрөгийн үлдэгдэлд дараах байгууллагуудын авлага байна. Тухайлбал:

- Монгол Улсын Хөгжлийн банкны дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж 746,692.6 сая төгрөг;

- Хадгаламжийн даатгалын корпорацын Хадгаламж банк дампуурснаас хадгаламж эзэмшигчдийн нөхөн төлбөрт санхүүгийн дэмжлэг олгосон эрх хүлээн авагчаас авах 53,941.1 сая төгрөг;
- Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 93.7 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банкны 25,163.6 сая төгрөгийн татвар, НДШ-ийн авлага байна.

Байгууллагаас авах 275,574.4 сая төгрөгийн авлагад материаллаг дүнтэй дараах авлага байна. Тухайлбал:

- Монгол Улсын Хөгжлийн банкны своп арилжааны болон бусад авлага 163,949.1 сая төгрөг;
- Ирээдүйн өв сангийн 98,193.3 сая, Төсвийн тогтворжуулалтын сангийн 3,346.6 сая төгрөгийн АМНАТ-ын авлага;
- Инженер технологийн дээд боловсрол төсөл тоног төхөөрөмж худалдан авахаар шилжүүлсэн 4,057.1 сая төгрөг;
- Зээлийн батлан даалтын сангийн найдваргүй зээлийг гэрээний дагуу банканд барагдуулсан 1,024.3 сая төгрөг;
- Засгийн газрын нөөц сангийн МИАТ ТӨХК-иас авах 989.8 сая төгрөг;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн дамжуулан зээлийн хүүгийн алдангийн авлага 991.4 сая төгрөг;
- Төрийн банк ХХК-ийн 822.6 сая төгрөг;
- ГЕГ-ын 765.1 сая төгрөгийн гүйцэтгэгчид банкны баталгаагаар шилжүүлсэн төлбөр.

Дараах байгууллагуудын ААН, иргэдэд олгосон 540,205.4 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байна. Тухайлбал:

- Дамжуулан зээлийн авлага Хөдөө, аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилтийн 83,568.6 сая, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн 128,995.6 сая, Бичил санхүүгийн хөгжлийн сангийн 10,507.9 сая нийт 223,072.1 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн авлага 79,099.1 сая, зээлийн хүүгийн авлага 196,487.7 сая төгрөг;
- Төрийн банк ХХК-ийн үндсэн зээлийн хүүгийн авлага 27,544.9 сая төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн авлага 14,003.9 сая нийт 41,548.8 сая төгрөгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Гаалийн ерөнхий газарт он удаан жил болсон нийт 38.3 сая төгрөгийн авлага байна. Үүнд:

- 2013-2015 онуудад үүссэн Завхан аймаг дахь Гаалийн хороо, хил хяналтын бусад байгууллагын гэрэл цахилгааны төлбөрийн 9.6 сая төгрөг;
- 2009 оноос өмнө үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй /хариуцагчийн мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй/ 26.1 сая төгрөгийн авлага;
- Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт 2000 оноос өмнө үүссэн орон сууцны ашиглалтын төлбөрийн 2.6 сая төгрөгийн авлага байна.

Татварын ерөнхий газарт он удаан жил болсон нийт 8.6 сая төгрөгийн авлага байна. Үүнд:

- Дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 5.3 сая төгрөгийн авлага байна. /Архангай аймаг Ардын банк 0.6 сая, Орхон аймаг Сэргээн босголт банк 1.1 сая төгрөг, Сонгинохайрхан Сэргээн болголт банк 2.2 сая, Хөвсгөл аймаг Сэргээн босголт банк 1.4 сая төгрөг/
- Сангийн яамнаас авах 2013-2014 онд үүссэн 2.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. /Хан-Уул дүүрэг 1.1 сая, Увс 0.6 сая, Хөвсгөл 0.6 сая төгрөг, бусад 5 аймаг 33.3 мянган төгрөг/
- Ажлаас гарсан ажилтантай холбоотой 1.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. /Багахангай 0.2 сая, Нийслэл 0.6 сая, Татварын ерөнхий газар 0.2 сая төгрөг/

Зээлийн батлан даалтын сангийн нийт гаргасан батлан даалтын 15.4 хувь нь чанаргүй, 2.6 хувь нь хугацаа хэтэрсэн, журмын дагуу найдваргүй авлагын нөөц байгуулаагүй, нөөц сан, найдваргүй авлагын нөөц, зээлийн хүү, амлалтын шимтгэлийн зардлууд, хадгаламж, харилцах дансны хүүгийн орлого, батлан даалтын хураамж, шимтгэлийн орлогуудыг аккруэл сууриар тооцоолон бүртгэх зарим

дансны ангиллуудыг зөв тодорхойлоогүй, Сангийн яаманд төлсөн шимтгэлийг аккруэл сууриар бүртгээгүйгээс 1.6 сая төгрөгийн авлагыг зардлаар тайлагнасан байна.

Үндэсний давхар даатгал ХК нь дараа тооцоогоор 53.2 сая төгрөгийг олгож, харилцах дансанд буцаан тушаалгасан боловч уг гүйлгээний утга тодорхойгүй;

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 17,896.8 сая, эцсийн үлдэгдэл 104,708.0 сая төгрөг болж, 86,811.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Урьдчилж гарсан зардал	17,894.4	85,283.3	67,388.9
Урьдчилгаа тооцоо	2.4	19,424.7	19,422.3
Бараа материал бэлтгэх урьдчилгаа		16,304.1	16,304.1
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	17,896.8	3,120.6	-14,776.2
Дүн	17,896.8	104,708.0	86,811.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	5,036.7	27,172.9	22,136.2
Төсөл/сан	70.8	52,103.8	52,033.0
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	12,789.3	25,431.3	12,642.0
Дүн	17,896.8	104,708.0	86,811.2

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 85,283.3 сая төгрөгөөс гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 9 төсөл, арга хэмжээний 50,006.1 сая төгрөгийн гадаадын тэтгэлгийн сургалтын төлбөр болон барилга байгууламж, тоног төхөөрөмжийн урьдчилгаа байна. Үүнд:

- Инженер технологийн дээд боловсрол төслийн гадаадын тэтгэлгийн сургалтын төлбөр 28,427.6 сая төгрөг;
- Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл хөрөнгө оруулалтын ажлын 12,460.9 сая төгрөг;
- Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг дэмжих төслийн 862.2 сая төгрөг;
- Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 1,673.3 сая төгрөг;
- Ногоон нуур 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төслийн 138.0 сая төгрөг;
- Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн 2,676.4 сая төгрөг;
- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төслийн 3,441.1 сая төгрөг;
- Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн гэрээт ажлын 205.2 сая, зөвлөх үйлчилгээний 108.9 сая, нийт 314.1 сая төгрөг;
- Бусад ТХН-үүдийн 12.5 сая төгрөг.

Мөн дараах газруудын урьдчилж гарсан зардлын 35,288.9 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнд:

- Төрийн банк ХХК-ийн 18,907.8 сая төгрөг;
- ГЕГ-ын гаалийн шинэчлэлийн тоног төхөөрөмжийн урьдчилгаа 8,154.4 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банкны 2,354.1 сая төгрөг;
- Үндэсний давхар даатгал ХК-ийн давхар даатгалын хойшлогдсон хураамжид 1,039.7 сая, ERP программ хийлгэх гэрээний 200.0 сая, бусад төлбөрт 32.1 сая төгрөг;

- Зээлийн батлан даалтын сангийн төслийн зээлийн хүү, амлалтын шимтгэлийн 2,249.3 сая, дамжуулан зээлийн шимтгэлийн 612.9 сая төгрөг;
- Сангийн яамны Asianmetal.com, Indmin.com, Sxcoal.com, Umetal.com зэрэг олон улсын үнэ ханшны мэдээллийн сайтуудын төлбөрт 43.8 сая, Монгол Улсын зээлжих зэрэглэл тогтоолгох жилийн үйлчилгээний төлбөрт 418.1 сая, санхүүгийн программын төлбөрт 194.8 сая, автомашин, жолоочийн хариуцлагын даатгал, санхүүгийн программын төлбөрт 2.2 сая, нийт 658.9 сая;
- ТЕГ-ын гүйцэтгэгчид банкны урьдчилгаа төлбөрийн баталгаагаар төлсөн 847.7 сая төгрөг;
- Бусад байгууллагуудын 231.9 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал.

Бараа материал, үндсэн хөрөнгө, бэлтгэх урьдчилгаа дансанд 19,424.7 сая төгрөгийн дараах үлдэгдэл байна. Үүнд:

- Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 төслийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн 940.4 сая төгрөг;
- Хууль сахиулахын их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн төв байрны сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төслийн гүйцэтгэгч компанид төлсөн 2,132.6 сая төгрөг;
- Цөмийн болон бусад аналитик аргаар хүнсний бүтээгдэхүүний эмийн болон химийн үлдэгдлийг шинэчлэх лабораторийн чадавх сайжруулах төслийн 47.6 сая төгрөг;
- ГЕГ-ын лабораторийн барилга 1,004.1 сая, шуурхай удирдлагын төв, гаалийн төв лабораторийн барилга 15,300.0 сая төгрөг.

2.8.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 19,123.2 сая, эцсийн үлдэгдэл 9,831.6 сая төгрөг болж, 9,291.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/ Бууралт-
Түүхий эд материал	50.9	77.2	26.3
Дуусаагүй үйлдвэрлэл	650.0	-	-650.0
Бэлэн бүтээгдэхүүн	12,862.8	890.3	-11,972.5
Хангамжийн материал	5,416.5	8,715.2	3,298.7
Мал амьтад	142.9	148.8	6.0
Дүн	19,123.1	9,831.6	-9,291.5
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	16,585.3	6,661.2	-9,924.1
Төсөл/сан		91.9	91.9
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,537.9	3,078.5	540.6
Дүн	19,123.2	9,831.6	-9,291.6

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал тайлант онд худалдан авсан 26,103.8 сая, хандиваар 20.8 сая, шилжүүлэн авсан 3,519.2 сая, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой 337.3 сая, нийт 29,981.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн зарцуулсан бараа материал 14,528.6 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 10,891.3 сая, төсөл хөтөлбөртэй холбоотой шилжүүлсэн 785.0 сая, нийт 26,204.3 сая төгрөгөөр хасагдсан байна.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэлд зарцуулах, ашиглахаар нөөцөлсөн дараах ГЕГ-ын 4,508.7 сая, Төрийн банк ХХК 2,839.1 сая, ТЕГ 1,347.2 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: Татварын ерөнхий газар

- Бараа материалыг бөөн дүнгээр зарлагдсан, шууд зардалд бүртгэсэн, дансны ангилал буруу бүртгэсэн, жилийн эцсийн тооллого хийгээгүй / Ховд аймаг 5.1 сая, Баянгол 3.3 сая, Сүхбаатар 11.4 сая, Багахангай дүүрэг 19.5 сая төгрөг/
- Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс 21.2 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн.
- Шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, жишиг нормоос илүү зарцуулсан /Чингэлтэй 0.3 сая, Сонгинохайрхан 1.2 сая, Налайх дүүрэг 4.8 сая, Орхон 2.1 сая, Дорнод аймаг 0.7 сая, төгрөг/

2.8.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 399,177.9 сая, эцсийн үлдэгдэл 1,837,341.1 сая төгрөг болж, 1,438,163.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	308,264.8	443,132.0	134,867.2
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	-	1,309,196.0	1,309,196.0
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	90,913.2	85,013.2	-5,900.0
Дүн	399,177.9	1,837,341.1	1,438,163.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага		74,135.7	74,135.7
Төсөл/сан			-
Төрийн сан		1,235,060.3	1,235,060.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	399,177.9	528,145.1	128,967.2
Дүн	399,177.9	1,837,341.1	1,438,163.2

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани ДИ БИ ЭМ Ассет менежмент ҮЦК ХХК-ийн арилжааны банкнуудад байршуулсан хадгаламж 8,836.9 сая төгрөг, Хадгаламжийн даатгалын корпорацын Монголбанкнаас худалдан авсан богино хугацаат үнэт цаас 434,295.0 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 1,309,196.0 сая төгрөгөөс гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 12 төсөл, арга хэмжээний зардлыг хуримтлуулж бүртгэсэн 1,305,781.9 сая төгрөгийн дараах ТХН-ийн зам гүүр, барилга байгууламж, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ажлууд бүртгэлтэй байна. Үүнд:

- Улаанбаатар-Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны хурдны авто зам барих төслийн зөвлөх үйлчилгээний 17,270.9 сая, авто замын ажлын 350,279.8 сая төгрөг;
- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 212,012.5 сая төгрөг;
- Улаанбаатар Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн 88,828.2 сая төгрөг;
- Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114.0 км хатуу хучилттай авто зам төслийн 109,837.1 сая төгрөг;
- Тайшир-Алтай ус хангамж төслийн 30,015.2 сая төгрөг;
- Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоох суурин газруудын хөгжил төслийн 38,429.5 сая төгрөг;
- Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэл төслийн 6,595.2 сая төгрөг;
- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, хийн хоолой байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах төслийн 39,904.3 сая төгрөг;
- Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам төслийн 149,857.4 сая төгрөг;

- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 1, 2 дахь шатны төслийн 167,360.9 сая төгрөг;
- Улиастай-Тосонцэнгэлд чиглэлийн 67 км автозам барих төслийн 24,669.3 сая төгрөг;
- Хилийн үйлчилгээг сайжруулах төслийн 1,958.7 сая төгрөг;
- Хөдөөд аж ахуйн хөдөөгийн хөгжил төслийн 2,167.9 сая төгрөг;
- Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн зөвлөх үйлчилгээний 3,444.2 сая, авто замын ажлын 48,494.5 сая төгрөг;
- Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 14,656.3 сая төгрөг.

Мөн он дамжин хэрэгжих барилга байгууламж, их засвар /Сангийн яамны 2,089.8 сая, ТЕГ-ын 1,324.3 сая/ нийт 3,414.1 сая төгрөгийг хуримтлуулан бүртгэсэн байна.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгийн дансанд дараах газруудын 85,013.2 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнд:

- Хадгаламжийн даатгалын корпорацын 2013 онд худалдан авсан Төрийн банкны хувьцаа 85,000.0 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банк Сэлэнгэ аймагт байрлах 304 га газрыг Бүрэн эрдэнэ монос ХХК-иас 2010 онд худалдан авсан газрын гэрчилгээ гараагүйгээс 13.2 сая төгрөг.

2.8.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 3,949,787.9 сая, эцсийн үлдэгдэл 4,568,783.9 сая төгрөг болж, 618,996.0 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/ Бууралт-
Урт хугацаат хадгаламж	54,991.4	60,117.1	5,125.7
Үнэт цаас	410,788.9	424,941.9	14,153.0
Урт хугацаат зээл	3,436,286.7	4,036,863.1	600,576.4
Урт хугацаат хөрөнгө оруулалт	47,720.9	46,861.8	(859.1)
Дүн	3,949,787.9	4,568,783.9	618,996.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	41,463.6	45,948.9	4,485.3
Төсөл/сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	3,908,324.3	4,522,835.0	614,510.7
Дүн	3,949,787.9	4,568,783.9	618,996.0

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт Монгол Улсын Хөгжлийн банкнаас төрийн болон хувийн хэвшлийн ААН-үүдэд олгосон урт хугацаат зээлийн 72,121.2 сая төгрөгөөр өссөн байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны 55 хувь буюу 2,529,157.6 сая төгрөг Монгол Улсын Хөгжлийн банкны, 43 хувь буюу 1,976,809.6 сая төгрөг Төрийн банк ХХК-ийн, 1.1 хувь буюу 49,824.3 сая төгрөг Үндэсний давхар даатгал ХК-ийн, 0.1 хувь нь бусад 9 байгууллагуудын үлдэгдэл байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд харьяа ТӨХК болон ХК-иудын хадгаламж, үнэт цаас, зээлийн 4,555,791.5 сая төгрөгийн дараах үлдэгдэл байна. Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн банкны урт хугацаат 2,371,446.5 сая төгрөгийн зээлээс ТӨААН-үүдэд олгосон 774,637.8 сая, хувийн хэвшлийн ААН-үүдэд олгосон 1,596,808.7 сая, үнэт цаас 147,418.3 сая, урт хугацаат хадгаламж 10,292.7 сая, нийт 2,529,157.6 сая төгрөг;
- Төрийн банк ХХК-ийн урт хугацаат 1,699,286.0 сая төгрөгийн зээлээс иргэдэд олгосон 1,554,627.8 сая, ТӨААН-үүдэд олгосон 713.0 сая, хувийн хэвшлийн ААН-

үүдэд олгосон зээл 143,891.5 сая, төсөвт байгууллагуудад олгосон 53.6 сая нийт 1,976,809.6 сая, үнэт цаас 277,523.6 сая төгрөг;

Мөн 45,948.9 сая төгрөгийг Засгийн газар гадаадын банканд хөрөнгө байршуулах болон ТӨААН-үүдийн дүрмийн санг нэмэгдүүлэх зорилгоор урт хугацаат хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнд:

- Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк 20,151.7 сая төгрөг;
- Олон Улсын хөрөнгө оруулалтын банк 5,500.0 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банкны дүрмийн сан 1,246.6 сая төгрөг;
- ҮЦТХТ ХХК-ийн дүрмийн сан 1,000.0 сая төгрөг;
- АТТҮЦК ХХК-ийн дүрмийн сан 3,049.1 сая төгрөг;
- Зээлийн батлан даалтын сангийн дүрмийн сан 300.0 сая төгрөг;
- Үндэсний давхар даатгал ХК-ийн 8,535.0 сая төгрөг;
- Монголын цахилгаан холбоо ХК-ийн 40 хувийг худалдан авах эх үүсвэр 6,166.6 сая төгрөг;

Аудитын илрүүлэлт: Сангийн яам нь санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт 45,948.9 сая, төрийн өмч 6,466.6 сая, хуримтлагдсан үр дүн 39,482.4 сая төгрөгийн дүнтэй 8 данс нэгтгэгдсэн ба эдгээр дансуудыг шат шатны төсөв захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдэхгүй ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэгдэж байна.

2.8.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 531,699.6 сая, эцсийн үлдэгдэл 971,216.2 сая төгрөг болж, 439,516.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.8 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/ Бууралт-
Биет хөрөнгө	382,023.7	810,413.6	428,390.0
Барилга, байгууламж, орон сууц	221,419.6	193,063.4	-28,356.2
Авто-тээврийн хэрэгсэл	18,381.3	25,539.3	7,158.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	118,777.1	116,340.7	-2,436.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	18,033.9	39,064.7	21,030.8
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7.3	7.3	-
Бусад үндсэн хөрөнгө	3,421.2	16,506.3	13,085.1
Дуусаагүй барилга, байгууламж	1,935.8	419,844.6	417,908.7
Ном	47.5	47.3	0.2
Биет бус хөрөнгө	37,581.1	41,806.6	4,225.6
Програм хангамж	17,893.4	18,864.2	970.8
Бусад биет бус хөрөнгө	19,687.7	22,942.4	3,254.7
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	112,094.8	118,996.0	6,901.2
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	41,005.4	21,219.7	-19,785.7
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	71,089.4	97,776.3	26,686.9
Дүн	531,699.6	971,216.2	439,516.8
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	222,594.9	200,889.0	-21,705.8
Төсөл/сан	272.1	422,479.7	422,207.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	308,832.6	347,847.5	39,014.9
Дүн	531,699.6	971,216.2	439,516.8

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь тодруулгаас

Оны эхэнд үндсэн хөрөнгийн элэгдэл 127,481.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан оны эцэст 145.792.0 төгрөгийн үлдэгдэлтэй болж 18,310.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 7,002.5 сая, үнэ төлбөргүй авсан 659.3 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 39,186.4 сая, төсөл хөтөлбөрүүдийн

санхүүгийн тайлан нэгтгэгдсэнтэй холбоотой шилжүүлэн авсан 1,234,989.6 сая, тайлант онд дахин үнэлсэн 196.3 сая, бусад 471,046.9 сая, нийт 1,753,081.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн холбогдох тогтоол шийдвэрийн дагуу акталсан 17,617.5 сая, худалдсан 125.7 сая, балансаас баланс шилжүүлсэн барилга, байгууламж 1,272,129.2 сая, бусад 23,647.2 сая, дахин үнэлгээ 44.7 сая, нийт 1,313,564.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 419,844.6 сая төгрөгөөс гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 8 төсөл, арга хэмжээний 415,406.8 сая, төгрөгийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын дараах үлдэгдэл байна. Үүнд:

- Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл 151,773.5 сая төгрөг;
- Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл 94,146.5 сая төгрөг;
- Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл 72,291.1 сая төгрөг;
- Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл 51,050.2 сая төгрөг;
- Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөл төсөл 26,279.4 сая төгрөг;
- Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл 17,075.7 сая төгрөг;
- Бусад 2 ТХН-үүдийн 2,790.5 сая төгрөг байна.

Мөн ГЕГ-ын 204.8 сая төгрөг, Сангийн яамны 1.2 сая төгрөг, Төрийн банк ХХК-ийн 30 салбар нэгжийн, дуусаагүй барилга байгууламжийн 4,231.7 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Бусад хөрөнгө дансанд хойшлогдсон татварын хөрөнгө ҮЦТХТ ХХК 9.4 сая, Монгол Улсын хөгжлийн банк 21,207.5, АТТ ХХК 2.8 сая, нийт 21,219.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө Монгол Улсын хөгжлийн банканд 97,776.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Татварын ерөнхий газар нь жилийн эцсийн тооллогыг хангалтгүй зохион байгуулсан, үндсэн хөрөнгө бодитоор оршин байгаагүй, хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн, акталсан хөрөнгийн устгал хийгээгүй, үндсэн хөрөнгийн карт хөтлөөгүй нийт 59.9 сая төгрөг /Баянгол 2.4 сая, Баянзүрх 4.8 сая, Чингэлтэй 23.9 сая, Багахангай 28.8 сая төгрөг/

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь 2018 онд худалдан авсан 25.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нь техникийн шаардлага хангаагүйгээс шүүхэд хандсан боловч нэхэмжлэлийн шаардлага хангаагүй гэх үндэслэлээр шүүх хүлээн авахаас татгалзсан;

Төрийн банк ХХК нь барилгын дахин үнэлгээг 2018 оны эцэст хийсэн бөгөөд санхүүгийн тайланд үнэн тусгаагүй байсанд өмнөх жилийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;

Үндэсний давхар даатгал ХК нь 158.4 сая төгрөгийн үлдэх өртөгтэй Малын индексжүүлсэн даатгалын программ, 4.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй нягтлан бодох бүртгэлийн программуудад үнэ цэний бууралтыг хүлээн зөвшөөрч, бүртгээгүй байна.

2.8.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6,986,744.7 сая, эцсийн үлдэгдэл 6,872,011.3 сая төгрөг болж, 114,733.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Богино хугацаат өр төлбөр:	1,464,694.2	1,470,582.7	5,888.5
Богино хугацаат үнэт цаас	61,679.5		-61,679.5
Богино хугацаат зээлийн өглөг	1,282,300.4	1,256,833.8	-25,466.6
Өглөг	83,197.7	154,462.3	71,264.6
Ажилчидтай холбогдсон өглөг	111.5	379.3	267.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,787.1	3,141.3	1,354.2
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		67.8	67.8
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	196.2	2,951.6	2,755.4
Зээлийн хүүгийн өглөг	34,087.5	38,442.4	4,354.9
Бусад өглөг	47,015.4	109,480.0	62,464.6

Урьдчилж орсон орлого	37,516.6	59,286.6	21,770.0
Урт хугацаат өр төлбөр:	5,522,050.5	5,401,428.6	-120,621.9
Урт хугацаат үнэт цаас	2,329,781.6	2,173,068.8	-156,712.8
Урт хугацаат зээл	3,192,268.9	3,228,359.8	36,090.9
Дүн	6,986,744.7	6,872,011.3	-114,733.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	195,386.9	220,591.4	25,204.5
Төсөл/сан	517,581.6	233,435.9	-284,145.7
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,273,776.2	6,417,984.0	144,207.8
Дүн	6,986,744.7	6,872,011.3	-114,733.4

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Төрийн банк ХХК нь Монгол банк, Монгол Улсын Хөгжлийн банк, ING банкнуудад худалдсан 228,286.1 сая төгрөгийн үнэт цаас болон Хадгаламж даатгалын корпорацын өрийн бичиг 61,679.5 сая төгрөгийг төлсөн, Монгол Улсын Хөгжлийн банк дотоодын зах зээлд гаргасан 21,465.0 сая төгрөгийн бондыг буцаан худалдан авснаас шалтгаалан богино, урт хугацаат үнэт цаас, бондын өр төлбөр буурсан. Мөн богино хугацаат өглөг 70,983.4 сая, урт хугацаат зээл 72,121.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Богино хугацаат зээлийн өглөг дансны 1,256,833.8 сая төгрөгийн үлдэгдэлд:

- Төрийн банк ХХК-ийн иргэд, ААН-үүдийн харилцах данс 783,238.3 сая, хугацаагүй хадгаламж 256,785.6 сая, банк санхүүгийн байгууллагуудын харилцахын үлдэгдэл 27,334.8 сая нийт 1,067,358.7 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банканд дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан хадгаламж 189,424.8 сая төгрөг;
- Цөмийн болон бусад аналитик аргаар хүнсний бүтээгдэхүүний эмийн болон химийн үлдэгдлийг шинэчлэх лабораторийн чадавхыг сайжруулах төслийн 47.6 сая төгрөг;
- Улаанбаатар хотын цэвэр агаар төслийн 2.7 сая төгрөг тус тус байна.

Бараа үйлчилгээний зардлын өглөг дансны 3,141.3 сая төгрөгийн үлдэгдэлд:

- Сангийн яамны гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний Монгол талын хөрөнгө оруулалтаас суутгасан барьцааны өглөг 2,861.1 сая төгрөг;
- Засгийн газрын хэрэг эрхлэх газарт ЗГНС-аас санхүүжүүлэх 62.2 сая төгрөг;
- Төслийн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 210.7 сая төгрөг;
- Эрүүл мэндийн салбарын хөтөлбөр-4 төслийн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 2,517.0 сая төгрөг;
- Үнэт цаасны хадгаламжийн төв ХХК-ийн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 4.5 сая төгрөг;
- ГЕГ-ын хөрөнгө оруулалтын ажлаас суутгасан барьцаа хөрөнгийн өглөгийн үлдэгдэл байна. 434.5 сая төгрөг тус тус байна.

Зээлийн хүүгийн өглөгийн үлдэгдэлд Монгол Улсын Хөгжлийн банк санхүүгийн байгууллагуудаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон 38,437.1 сая, Хадгаламж даатгалын корпорацын 5.3 сая төгрөг тус тус байна. Тайлант онд Монгол Улсын Хөгжлийн банк Жэй Пи Морган Чэйс банкттай 100.0 сая ам.долларын зээлийн хөтөлбөрийн гэрээ байгуулснаас зээлийн хүү өмнөх оноос өссөн байна.

Бусад өглөг дансанд харьяа газруудын 109,480.0 сая төгрөгийн үлдэгдэлд:

- Төсөл, хөтөлбөрүүдийн худалдан авалт, бусад өглөг 50,424.1 сая төгрөг;
- Зээлийн батлан даалтын сангийн зээлдүүлэгчдээс төвлөрүүлсэн барьцаа хөрөнгийн хуримтлалаас 1,024.3 сая төгрөг;
- Монгол Улсын хөгжлийн банкны бараа, ажил гүйцэтгэлийн гэрээний дагуу үүссэн ААН-үүдэд болон татвар, НДШ-д өгөх 20,118.4 сая төгрөг;

- Төрийн банк ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой үүссэн 11,631.4 сая, татвар, НДШ-ийн 4,136.3 сая, банк хоорондын клирингийн тооцоо, гадаад гуйвуулгын 6,288.2 сая нийт 22,055.9 сая төгрөг;
- Үндэсний давхар даатгал ХК-ийн давхар даатгагчдад өгөх 386.9 сая, Малын индексжүүлсэн даатгалын сурталчилгаанд зориулан даатгалын компаниудаас төвлөрүүлсэн 86.4 сая, аудитын үйлчилгээний хөлс 21.4 сая, ААНОАТ-ын өглөг 158.9 сая, ногдол ашгийн орлогоос суутгасан татварын өглөг 1,000.0 сая, нийт 1,653.6 сая төгрөгийн өглөг;
- Бусад байгууллагын 14,203.7 сая төгрөгийн өглөг байна.

Урьдчилж орсон орлого 59,286.6 сая төгрөгийн үлдэгдэлд:

- Засгийн газрын өрийн баталгааны сангийн өрийн баталгаа гаргасны орлого 35,425.3 сая төгрөг;
- Зээлийн батлан даалтын сангийн зээлийн баталгааны орлого 186.1 сая төгрөг;
- Үндэсний давхар даатгал ХК-ийн хураамжийн нөөц 926.6 сая, 9 даатгалын компаниас алдагдал зогсоох гэрээний дагуу Малын индексжүүлсэн даатгалын 263.5 сая, нийт 1,190.1 сая төгрөг;
- Эрүүл мэндийн салбарын хөтөлбөр-4 төслийн 645.2 сая, Инновацыг дэмжих төсөл 378.1 сая, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 18,058.6 сая төгрөгийн он дамжиж орсон орлого;
- Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зээлийн баталгааны урьдчилж орсон орлого 3,377.6 сая төгрөг;
- Бусад байгууллагын 25.6 сая төгрөг байна.

Урт хугацаат үнэт цаасны 2,173,068.8 сая төгрөгийн үлдэгдэлд Хөгжлийн банкны дотоод зах зээлд гаргасан бонд 125,000.0 сая төгрөг, Япон улсын Самуурай бонд, Сингапур улсын Сэргэн мандалт бондын 2,048,068.8 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба үүнээс тайлант оны ханшийн алдагдал 71,573.2 сая төгрөг байна.

Урт хугацаат зээлд харьяа байгууллагуудын 3,262,257.5 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн банкны гадаадын арилжааны банкнаас авсан зээл болон тайлант онд Жэй Пи Морган Чэйс Банкны 100.0 сая ам.долларын зээл, Внэшэконом банкнаас 18 сая еврогийн зээл нийт 764,288.4 сая төгрөг;
- Төрийн банк ХХК-ийн урт хугацаат өр төлбөр 1,941,223.8 сая төгрөг;
- Хадгаламж даатгалын корпорац нь Монгол банкнаас хадгаламж банкны санхүүгийн дэмжлэг, төрийн банкны хувьцаа худалдан авах, зорилгоор авсан зээлийн үлдэгдэл 149,001.2 сая төгрөг;
- Үнэт цаасны хадгаламжийн төв ХХК-ийн 100.0 сая төгрөг;
- Арилжааны төлбөр тооцоо ХХК-ийн 2.8 сая төгрөг;
- Үндэсний давхар даатгал ХК нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан хамтын эрсдэлийн сангийн 1,927.5 сая, эрсдэлээс хамгаалах сангийн 3,900.1 сая төгрөг;

Мөн гадаадын зээлээс дамжуулан зээлдүүлсэн 401,813.5 сая төгрөгийн урт хугацаат дамжуулан зээлийн үлдэгдэл байна. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах төслийн 130,648.0 сая төгрөг;
- Бичил санхүүгийн хөгжлийн сангийн 15,854.4 сая төгрөг;
- Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 34,112.8 сая;
- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төслийн 62,818.9 сая төгрөг;
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн төсөл Нэмэлт санхүүжилт төслийн 86,088.3 сая төгрөг;
- Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төслийн 72,291.1 сая төгрөг.

Аудитын илрүүлэлт:

Төрийн банк ХХК:

- Зээлдэгч Жиансу Жунжиан Жианшин, Шинэ Азиа Групп нар зээл авахдаа харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл, авлага, бараа материал, гэрээний дагуух ирээдүйн орлого зэргийг барьцаалсан ба банк барьцаа хөрөнгө болох ирээдүйн орлогын харилцан тохиролцсон үнийг тодорхойлохдоо 100 хувиар тооцсон бөгөөд бусад барьцаа хөрөнгүүд нь тэг үнэлгээтэй байсан;
- Хоёр зээл дээр хослуулан барьцаалсан бөгөөд харилцсан тохиролцсон үнэ нь тухайн гэрээнд хэд байхыг нь тусгаагүй;
- Банкны баталгааны эх үүсвэрийг нь харилцагчийн харилцах данснаас тусгаарлах мемориалын баримт болон эх үүсвэрийг балансын гадуурх дансанд бүртгэж байгаа, хоёр зээл дээр хослуулан барьцаалсан бөгөөд харилцсан тохиролцсон үнэ нь тухайн гэрээнд хэд байхыг нь тусгаагүй байсан Хэд хэдэн эх үүсвэртэй банкны баталгааны маягт дээр теллер болон салбар (тооцооны төв)-ын захирлаар гарын үсэг зуруулаагүй, хэд хэдэн эх үүсвэртэй банкны баталгааны маягт дээр теллер болон салбар (тооцооны төв)-ын захирлаар гарын үсэг зуруулаагүй, банкны баталгааны эх үүсвэрийг нь харилцагчийн харилцах данснаас тусгаарлах мемориалын баримт болон эх үүсвэрийг балансын гадуурх дансанд бүртгэж байгаа, Банкны баталгааг “Графт” системд эх үүсвэртэй болон эх үүсвэргүй байдлаар 2 ангилж бүртгээгүй тохиолдлууд гарсан;
- Зээлээр авсан эх үүсвэрийн үлдэгдлийн хувьд тухайн харилцагчидтай болон холбогдох төслийн нэгжтэй тооцоо нийлээгүй болон үлдэгдлийн баталгаажуулалт хийгдээгүй байсан (Жижиг, дунд үйлдвэрлэлийн төслийн сантай холбоотой зээлийн үлдэгдэл, дээр гэрээ байхгүй мөн ямар нэгэн төлбөр төлөх үүргийн баталгаажуулалт байхгүй, эдгээр үлдэгдэл нь 2017 оноос хойш бүртгэлтэй байсан байна. Энэ нь гуравдагч талтай тогтмол тооцоо нийлээгүйтэй холбоотой үүссэн;
- Хугацаа хэтэрсэн зээлийн хүүг автоматаар балансын гадуур хуримтлуулдаг, 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн зээлийн хүүг балансын дотуур хуримтлуулахыг зогсоодог бөгөөд энэ нь СТОУС-д нийцэхгүй.

Үндэсний давхар даатгал ХК 2018-2019 оны жилийн эцсийн байдлаар ажилтнуудын ажилласан хугацаанд ногдох амралтын цалингийн нөөц болон Компанийн урамшууллын журамд заасан ажлын үр дүнгийн урамшууллыг урьдчилан тооцож, тайлант хугацааны өглөг үүсгэж, зардлаар тооцоогүй байна.

2.8.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,939,969.5 сая, эцсийн үлдэгдэл 4,653,054.7 сая төгрөг болж, 2,713,085.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт/+, бууралт /-
Засгийн газрын оруулсан капитал	103,132.1	105,127.8	1,995.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,341,767.0	1,362,682.1	20,915.1
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	38,130.6	43,130.6	5,000.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	110,108.4	106,456.8	-3,651.6
Нийт өмчийн дүн	1,593,138.1	1,617,397.3	24,259.2
Хуримтлагдсан үр дүн	290,392.9	2,975,749.5	2,685,356.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,438.5	59,907.9	3,469.4
Дүн	1,939,969.5	4,653,054.7	2,713,085.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	314,342.7	444,919.5	130,576.8
Төсөл, сан	-36,131.9	2,350,395.4	2,386,527.3
Төрийн сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,661,758.7	1,857,739.8	195,981.1
Дүн	1,939,969.5	4,653,054.7	2,713,085.2

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үр дүн 1,128,680.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Бусад ТЕЗ-даас шилжиж ирсэн 51 ТХН-үүдийн хуримтлагдсан үр дүн 1,082,391.6 сая төгрөгийг шилжүүлэн бүртгэсэн;
- ТӨХК-ууд авлагын өнөөгийн үнэ цэний зөрүү, нөөц сан байгуулсан, өглөг, авлага залруулсан, урьдчилж орсон орлого, тусламжийн эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлтийг залруулсан 48,976.3 сая төгрөг;
- Зээлийн батлан даалтын сан 2,108.8 сая төгрөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн;

- Элэгдлийн зөрүү залруулсан 326.9 сая төгрөг.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт данс 362.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Зээлийн батлан даалтын сангийн эрсдэлийн сан болон үүрэг гүйцэтгэлийн орлого, зардлын зөрүү 904.1 сая төгрөг;
- Төрийн банк ХХК дахин үнэлсэн хөрөнгийн элэгдлийг хассан 786.0 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банк хувьцааны дахин үнэлгээтэй холбоотой өөрчлөлт 231.6 сая төгрөг;
- Элэгдлийн зөрүү залруулсан 19.8 сая төгрөг.

Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт данс Үндэсний давхар даатгал ХК дүрмийн сангаа нэмэгдүүлсэн 5,000.0 сая, Сангийн яамны газрын дахин үнэлгээгээр тус тус нэмэгдүүлж, Бичил санхүүгийн хөгжил сан хөрөнгө хассан 10.8 сая төгрөгөөр хасаж нийт 4,992.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмчид гарсан өөрчлөлт данс 71,471.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл аудитын зөвлөмжийн дагуу газар чөлөөлөлттэй холбоотой гарсан зардлыг капиталжуулсан 32,968.6 сая төгрөг;
- Төрийн банк ХХК үнэт цаасны дахин үнэлгээ хийсэн 20,354.9 сая төгрөг;
- Үндэсний давхар даатгал ХК алдагдлаас хамгаалах нөөц сангаа нэмэгдүүлсэн 19,000.0 сая төгрөг;
- ТХН-үүд 852.1 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг бууруулсан.

Аудитын илрүүлэлт: Үндэсний давхар даатгал ХК нь тайлант онд "Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын үр дүн"-гийн тооцооллыг Хамтын эрсдэлийн сангийн тогтоол шийдвэрээр баталгаажуулаагүй нягтлан бодох бүртгэлд тусгасан.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн 2019 оны хуульд зааснаар тайлант онд 7,387,196.7 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 7,900,338.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 106.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого				/сая төгрөг/	
Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
Нийт төвлөрүүлэх орлого	7,387,196.7	7,900,338.0	513,141.4	106.9	
Татварын ерөнхий газар	4,117,000.0	4,508,969.9	391,969.9	109.5	
Үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	322,000.0	100,219.3	-221,780.7	31.1	
Ирээдүйн өв санд	1,068,520.0	1,048,601.0	-19,919.0	98.1	
Гаалийн ерөнхий газар	2,949,695.1	3,153,770.3	204,075.2	106.9	
Сангийн яам	50,737.4	89,256.4	38,519.0	175.9	
Гадаад эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	123,764.2	63,099.4	-60,664.8	51.0	
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	146,000.0	85,242.0	-60,758.0	58.4	

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолыг Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр хүчингүй болгосон, “Эрдэнэс Монгол” ХХК, “Багануур” ХК улсын төсөвт ноогдол ашгийн орлогоо төвлөрүүлэх боломжгүй зэрэг шалтгаанаар “Ирээдүйн өв сан”-д төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 19,191.0 сая төгрөгөөр биелэгдээгүй байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 2,692,976.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,498,205.7 сая төгрөгийг урсгал зардалд, 1,078,107.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 119,428.0 сая төгрөгийг дотоод эх үүсвэрээс олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,568,496.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,096,280.1 сая төгрөгийг гадаад зээлийн, 146,000.0 сая төгрөгийг тусламжийн эх үүсвэрээс, 5,964.2 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх төлбөрийг 123,764.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,518,218.6 сая төгрөгийг санхүүжүүлж 50,277.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн дутуу олгосон, тусламжийн санхүүжилтээс 85,242.0 сая төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх төлбөрөөс 63,099.4 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 12,118.4 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7,907.7 сая төгрөгөөр давсан нь ТЕГ-ын орлогын төлөвлөгөөний биелэлт болон төсөл, хөтөлбөрүүдийн дамжуулан зээлийн авлагыг үндсэн үйл ажиллагааны орлогоор орлогоор тооцсонтой холбоотой.

Туслах үйл ажиллагааны орлого 2,418.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 665.5 сая төгрөгөөр давсан нь төсөл, хөтөлбөрүүдийн арилжааны банканд байршиж байгаа харилцахын хүүгийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор тооцсон нь нөлөөлсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,477,096.5 сая төгрөг буюу 21,109.2 сая төгрөгөөр дутуу зарцуулж 98.6 хувьтай байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй илүү, дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Цалин, НДШ, ашиглалтын зардал, хангамжийн материал, норматив зардал, эд хогшил урсгал засвар, томилолтын зардлуудыг 8,075.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Хөшгийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад ороогүйгээс 99 орон тоо, гаалийн шинэчлэлийн 43 орон тоог оны эцэст нэмэгдүүлсэнтэй холбоотой зарцуулаагүй;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр бүлгийн дүнгээр 9,522.0 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь төсөл, хөтөлбөрүүдийн арилжааны банкаар гарсан төлбөр болон санхүүжүүлэгч байгууллагаас хийгдсэн шууд төлбөрөөс шалтгаалсан;
- Засгийн газрын нөөц сангийн удирдах байгууллагын тогтоол, шийдвэр гараагүйн улмаас 5,622.7 сая төгрөгийг зарцуулаагүй;
- Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөрийг 4,532.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь тухайн жилийн үйл ажиллагаа, валютын ханшийн өөрчлөлт нөлөөлсөн;
- Засгийн газрын урсгал шилжүүлэг бүлгийн дүнгээр 7,144.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь ГЕГ-аас 264.4 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал, Сангийн яам 1,491.9 сая төгрөгийн олон улсын байгууллагын гишүүнчлэлийн төлбөрийн гүйцэтгэл бага гарсан, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийн зардал 5,229.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн;
- Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 4 төсөл, хөтөлбөрийн 102,111.5 сая санхүүжилтийг батлагдсан төсвийн дээд хязгаараас илүү олгосон зэргээс голлон шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээнд 134,386.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 113,588.5 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл гараагүй УГЕГ-ын 31,752.1 сая төгрөгийн, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 222.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг барьцаа дансанд байршуулсан. Мөн төсөл, хөтөлбөрүүдийн Монгол талын хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгаа барьцаагаар 2,861.1 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулж өглөгөөр бүртгэсэн байна.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс авсан хандив тусламжийн 83.9 сая төгрөг, орон нутгийн төсвийн эрх захирагчдаас 1,199.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс олгосон орлого 2,189.2 сая төгрөг, төсвийн байгууллагын нэмэлт үйл ажиллагааны орлого 2,389.6 сая төгрөг нийт 5,862.6 сая төгрөгийн

орлогыг төвлөрүүлснээс 5,524.3 сая төгрөгийг зарцуулж, 338.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 286.3 сая төгрөгийг буцаан авахаар авлага үүсгэн бүртгэсэн байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 164 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс итгэл үзүүлсэн 4 байгууллага, 41 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 119 санхүүгийн тайлан аудитад хамрагдсан байна.

Аудитаар 101 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 8 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, 8 төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн тайланд гэрээт аудитын компаниуд донор орнуудтай байгуулсан гэрээний дагуу аудит хийж байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 516,352.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 289,717.1 сая төгрөгийн алдааг залруулж, 191.2 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт тогтоож, 553.7 сая төгрөгийн зөрчилд 40 албан шаардлага өгч, 225,890.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 188 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 12.2 сая төгрөгөөр урьдчилгааг дутуу, 13,068.4 сая төгрөгөөр бараа материалыг илүү, 150,845.2 сая төгрөгөөр бусад эргэлтийн хөрөнгийг дутуу, 33,869.4 сая төгрөгөөр урт хугацаат зээлийг илүү, 1.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг дутуу, 36,126.2 сая төгрөгөөр өр төлбөрийг илүү, 139,931.2 сая төгрөгөөр цэвэр хөрөнгийг дутуу, 300.0 сая төгрөгөөр засгийн газрын оруулсан капитал /төрийн-ТӨҮГ/-ыг илүү, өрийн 140,401.8 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг дутуу, 103,804.9 сая төгрөгөөр өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн өмчийн дүнг дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 84,310.3 сая төгрөгөөр үйл ажиллагааны орлогыг илүү, 92,733.6 сая төгрөгөөр татварын бус орлогыг дутуу, 177,043.9 сая төгрөгөөр тусламж санхүүжилтийн орлогыг илүү, 215,341.6 сая төгрөгөөр үйл ажиллагааны зардлыг илүү, 216,941.6 сая төгрөгөөр урсгал зардлыг илүү, 171,638.9 сая төгрөгөөр хүүгийн зардлыг илүү, 1,600.0 сая төгрөгөөр хөрөнгийн зардлыг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд 2,099.1 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансыг дутуу, 137,832.0 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 324,468.9 сая төгрөгөөр татварын бус орлого дансыг илүү, 1.7 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг дутуу, 5,716.0 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг илүү нэгтгэсэн;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 130,637.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа 2 төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгч аудитаар нийт 34,083.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 33,149.9 сая төгрөгийн алдааг залруулж, 168.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 96.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 668.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 56 байгууллагаас 4 байгууллагад итгэл үзүүлж, 6 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 45, Багахангай дүүргийн татварын хэлтэст “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,326.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,579.1 сая төгрөгийн алдааг залруулж, 12.0 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 243.2 сая төгрөгийн зөрчилд 29 албан шаардлага, 491.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 91 зөвлөмж өглөө.

Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн өмчит 9 аж ахуйн нэгж, байгууллагад аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 3,304.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,269.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 34.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 26 зөвлөмж өглөө.

Монгол Улсын Хөгжлийн банкны 2019 оны санхүүгийн тайланд “КПМЖ аудит” ХХК аудит хийж байгаа бөгөөд аудитын тайлан нь эцэслэгдэж, аудитаар өгсөн зөвлөмж нь ирээгүй байна.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 4 Засгийн газрын тусгай сангаас 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Засгийн газрын нөөц санд “Зөрчилгүй” 1 дүгнэлт өгч, 2 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Төсөл, хөтөлбөрийн 93 нэгжийн 32 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 45, “Хязгаарлалттай” 8 дүгнэлт өгсөн, 8 төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн тайланд гэрээт аудитын компаниуд донор орнуудтай байгуулсан гэрээний дагуу аудит хийж байна.

Аудитаар нийт 226,502.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 132,220.2 сая төгрөгийн 39 алдааг залруулж, 10.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 214.2 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 94,058.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 54 зөвлөмж өглөө.

Төсөл хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл

- Цалингийн тооцооны хүснэгтээр 53.4 сая төгрөгийн НДШ-ийг тооцсон боловч өглөгийг тайлагнаагүй;
- Санхүүгийн тайланд тусгагдсан 28.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй бүртгэлд тусгаагүй;
- Он дамжиж ирсэн 1,190.8 сая төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг бүрэн барагдуулаагүй бусдад өгөх өглөгөөр тайлагнасан байна.

Инженер технологийн дээд боловсрол төсөл

- Тус төслийн 2019 оны шатахууны зарцуулалтын тооцоог шалгаж үзэхэд нийт 7.8 сая төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулснаар тайлагнасан боловч жолоочийн тооцооны хуудас маягт Т-4 хөтлөөгүй, сар бүр шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл

- Зээлийн батлан даалтын сангаас буцаан төвлөрүүлсэн 3,438.8 сая төгрөгөөс валютын ханшийн зөрүүгийн олз болох 61.2 сая төгрөгийг бүртгээгүй;
- бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 6.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл

- Төмөр замын дохиолол холбооны инженерийн 2019 оны хөлсөөр ажиллах гэрээг сунгаагүй 32.6 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл

- Тайлант хугацааны 39,451.8 сая төгрөгийн худалдан авалтыг НӨАТ-ын хэрэглэгчийн системтэй тулган шалгахад 24,338.3 сая төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй, э-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд НӨАТ-ыг санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн;
- 0.1 сая төгрөгийн бараа материалыг зардалд шууд бүртгэсэн зөрчлүүд давтагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварыг дээшлүүлэх төсөл

- Тайлант хугацааны 16,569.3 сая төгрөгийн худалдан авалтыг 15,952.9 сая төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй, э-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд НӨАТ-ыг санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл

- Төслийг удирдах гарын авлагад НӨАТ-ын хөнгөлөлтийн талаар тодорхой заалт, холбогдох өөрчлөлт ороогүй байхад гүйцэтгэгч нарт НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлсэн;
- Зөвлөх, гүйцэтгэгч нарт олгосон санхүүжилтийн дүнг НӨТ-ын системд 51,938.7 сая төгрөгийг бүртгээгүй;
- Төслийн гүйцэтгэл гэрээний дагуу хийгдээгүй, ажлын явц хангалтгүй байна.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл

- Увс аймагт ажилласан томилолтын зардлын зам хоног болон байрны зардлын мөнгийг Улаанбаатар хотын зам хоног, байрны зардлын хэмжээгээр тооцон илүү олгосон байна.

Хөвсгөл НБЦГОБИ Амьжиргааг дэмжих тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл

- Төслийн нэгжийн хөдөө орон нутагт ажилласан 9.6 сая төгрөгийн томилолтын зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тооцож хянадаггүй.
- Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх 5.6 сая төгрөгийн автомашины шатахууныг нормоор тооцож олгоогүй, зарцуулалтад хяналт тавьдаггүй байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл

- Тайлант онд дотоод албан томилолтой холбоотой 3.3 сая төгрөгийн шатахууны зардал гарсан бөгөөд уг зардлыг тээвэр, шатахууны зардал гэж бүртгэж толилуулсан;
- Буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаануудад 6.3 сая төгрөгийн нэгжийн үнэлгээтэй 14 ширхэг дрон мөн 204.8 сая төгрөгийн өглөгтэй галд тэсвэртэй хувцсыг хүлээлгэн өгөхдөө хөрөнгө хүлээлцэх акт дээр хүлээн авсан хүний гарын үсэг зуруулсан хэдий ч тамга тэмдэг дарж баталгаажуулаагүй;
- Тайлант хугацаанд 6.0 сая төгрөгийн тээвэр, шатахууны зардлаар бүртгэсэн дотоод томилолт болон Улаанбаатар хотод албан хэрэгцээнд гаргасан зардлыг томилолтын зардал, тээвэр, шатахууны зардал гэж тус тусад нь салгаж бүртгээгүй байна.

4-р цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл

- Тайлант онд Сангийн яамны 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10/572 албан бичгээр төслийн ажилтнуудын цалин шинэчлэн тогтоож ирүүлсэн сүлжээг мөрдсөн байна. Ажилтнуудын цалин шинэчлэн тогтоож ирүүлсэн сүлжээг мөрдсөн байна. Ажилтнуудын 2018 оны хөлсөөр ажиллах гэрээнд 2019 онд ажиллуулах сунгалтыг хийсэн боловч Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газраас санхүүгийн ажилтны гэрээг сунгаагүй, 31.3 сая төгрөгийн цалинг тушаал, шийдвэргүй олгосон байна.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл

- Төслийн түрээсэлж буй 200 м.кв оффисын байрны түрээсийн 1м.кв-ийн сарын тариф нь 0.05 сая төгрөг буюу ТӨБЗГ-аас баталсан түрээсийн хязгаараас 0.02 сая төгрөгөөр өндөр байгаагаас тайлант онд нийт 36.0 сая төгрөгийн үр ашиггүй түрээсийн зардал гаргасан байна. Түүнчлэн Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 6 ажилтантай боловч 200 м.кв байр түрээсэлж байгаа нь олон улсын ажлын байрны орон зайн стандартад заасан 1 хүнд ногдох ажлын зай, талбайн хэмжээнээс хэт өндөр байна.

Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг дэмжих төсөл

- Төсөл хэрэгжүүлэх нэгж 92.8 сая төгрөгийн е-баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтдаа хавсаргаагүй;
- 2019 оны 8 дугаар сард зохион байгуулсан Татварын ерөнхий газрын удирдлагууд болон сумдын татварын улсын байцаагчдын сургалтын оролцогчдод олгосон 37.6 сая төгрөгийн замын унааны зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй буюу унааны мөнгийг сургалтад оролцогчид олгосон эсэх нь тодорхой бус;

- Төслийн түрээсэлж буй 120 м.кв оффисын байрны түрээсийн 1м.кв-ийн сарын тариф нь 37.0 мянган төгрөг байна. Энэ нь ТӨБЗГ-аас баталсан түрээсийн хязгаараас 0.8 сая төгрөгөөр өндөр байгаа ба нийт 5.9 сая төгрөгийн үр ашиггүй түрээсийн зардал гаргасан;
- Төслийн гүйцэтгэл гэрээний дагуу хийгдээгүй, ажлын явц хангалтгүй байна.

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл эд хариуцагч солигдоход болон жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй өөр төсөлд ашиглуулсан, хадгалалт хамгаалалт, хяналт хангалтгүй. Үндсэн хөрөнгийн хяналтын тооллого хийхэд нийт 0.4 сая төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг зөөврийн хатуу диск бодитоор байхгүй, 27.7 сая төгрөгийн хөрөнгө бодитоор оршин байгаа эсэхийг нотлох боломжгүй байна.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ЗГСНТ-аар авч үзэх асуудлууд:

- Өрийн удирдлагын тухай хууль 2015 онд батлагдаж тус хуулийн 29.9-д "Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар баталж, мөрдүүлнэ" гэж заасан боловч, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-ыг Өрийн удирдлагын хууль болон Өрийн удирдлагын стратегийн баримт бичигтэй уялдуулан шинэчилж батлуулаагүй, өмнөх аудитын зөвлөмж биелүүлээгүй;
- Тайлант онд гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 21 ажлын санхүүжилтийн 214,430.5 сая төгрөгийг захиалагч байгууллагын санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөнд хуримтлуулан бүртгүүлээгүй, Сангийн яам байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайланд хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгө, хаагдсан данс гэх мэт ангилалд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Өмнөх онуудад гадаадын зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 5 ажлын санхүүжилт 104,598.1 сая төгрөгийн хөрөнгө, эх үүсвэрийг санхүүгийн тайланд хуримтлуулан бүртгэж, холбогдох шат шатны санхүүгийн тайланд нэгтгээгүй;
- Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн өглөгийг дамжуулан зээлийн авлага болон тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 154,061.1 сая, Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн 7,552.4 сая, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 737.2 сая, нийт 162,350.7 сая төгрөгийн дамжуулан зээлдсэн зээлийн өглөг санхүүгийн тайланд бүртгэлгүй;
- Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн өглөгийг дамжуулан зээлийн авлага болон тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад Засгийн газрын 2015 оны 464 дугаар тогтоолыг үндэслэн Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төслийн дамжуулан зээлийн авлага 72,291.1 сая төгрөгийг бүртгээгүй;
- Монгол Улсын Хөгжлийн банкны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг зөрчилд өгсөн зөвлөмжийг харгалзах.

МУНТГТ-аар авч үзэх асуудлууд:

- Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай 2017 онд 3 жилийн хугацаатай байгуулсан өргөтгөсөн санхүүгийн хөтөлбөрийн 2,384.3 сая ам.долларын амлалтаас нийт 1,266.7 сая ам.долларын санхүүжилт авч, 53.1 хувьтай байгаа нь Монгол Улсын банкны салбарын хөрөнгийн чанарын үнэлгээнд тавигдсан шаардлага хангагдаагүйгээс хөтөлбөрийн хэрэгжилт хойшлогдсонтой холбоотой байна. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш төсвийн дэмжлэгт 1,045.3 сая ам.доллар буюу 2,635,114.0 сая төгрөгийг авч ашигласнаас тайлант онд Азийн хөгжлийн банк, БНСУ-аас нийт 408,134.4 сая төгрөгийн санхүүжилт олгосныг төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зарцуулсан;

- Дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс төсөвт төвлөрүүлэхээр төсвийн тухай хуулиар батлагдсан төсөв 123,764.1 сая төгрөг байна. Үүнээс 4000, 100000 айлын орон сууц хөтөлбөрийн эргэн төлөлтийг 15,436.2 сая төгрөгөөр дутуу, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчаас авах 35,000.0 сая төгрөг нийт төсөвт төвлөрүүлэх 50,436.2 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн;
- Гадаад зээлийн ашиглалт 73,405.0 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд дутуу тайлагнасан;
- Эрдэнэс Таван Толгой ХК-ийн ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолыг Засгийн газрын 2019 оны 4 сарын 10-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр хүчингүй болгосон, Эрдэнэс Монгол ХХК, Багануур ХК улсын төсөвт ногдол ашгийн орлого төвлөрүүлэх боломжгүй зэрэг шалтгаанаар Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 19,191.0 сая төгрөгөөр биелэгдээгүй байна.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн 93 төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлагнал, хөрөнгийн зарцуулалт, дамжуулан зээлийн авлага, өр төлбөрийн гэрээ, гүйцэтгэлийн үр дүн болон дууссан төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа, чиг үүргийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлээгүй санхүүгийн тайланд гүйцэтгэлийн аудит оруулах шаардлагатай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Сангийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 113 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Залруулагдаагүй 226,635.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 228,425.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.3.1 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт 45,949.0 сая, төрийн өмч 6,466.6 сая, хуримтлагдсан үр дүн 39,482.4 сая төгрөгийн дүнтэй 8 данс нэгтгэгдсэн ба хөрөнгийн дүн шат шатны төсөв захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдэхгүй ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэгдэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан, нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн нэгтгэсэн тайлан үнэн зөв нэгтгэгдэхгүй байх, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, толилуулга ба тодруулга, уялдаатай байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа ТӨХК-ууд болон бусдад оруулсан хөрөнгө оруулалтыг харьяалах төсөв захирагчийн санхүүгийн тайланд тайлагнаж, баталгаажуулж байх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Дамжуулан зээлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

- Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 4 төсөл, арга хэмжээний 102,111.7 сая төгрөгийг эдийн засгийн ангилал зөрүүлэн дотоод зээлийн эргэж төлөгдөх зээлийн

эдийн засгийн ангилалд тайлагнасан, нийт эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх 11 төсөл арга, хэмжээний санхүүжилт гүйцэтгэлээр 239,921.8 сая төгрөг байгаа ба батлагдсан төсвөөс 118,921.8 сая төгрөгөөр хэтэрсэн;

- Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн зээлийн эх үүсвэрээс Зээлийн батлан даалтын санд дамжуулан зээлдүүлсэн 58.6 сая ам.долларын гэрээг төгрөгөөр байгуулж, 6,260.1 сая төгрөгийн ханшийн зөрүүний алдагдал хүлээсэн байна. Эдгээр нь:

Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйл. Улсын Их Хурал төсөв батлах 33.1-д "Улсын Их Хурал Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн, төсвийг энэ хуулийн 8.4-т заасан цаглабарын дагуу хуульчлан батална" мөн хуулийн 33.2-д Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална, 33.2.8-д "төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр";

Өрийн удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6-д "Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний нөхцөлийг Засгийн газрын тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан тодорхойлох бөгөөд төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтална" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Авлага өр, төлбөр үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хууль, журам мөрдөгдөхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг мөрдөж ажиллах, дамжуулан зээлийг гэрээг тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтлан байгуулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Төсөл хөтөлбөрийн нэгжтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

- Дууссан төслийн 146,502.4 сая төгрөгийн дамжуулан зээлийн өглөг, 179,765.7 сая төгрөгийн нийт хөрөнгийн дүнтэй үйл ажиллагаа, чиг үүргийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлээгүй 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн, үүнээс 15,854.4 сая төгрөгийн дамжуулан зээлийн өглөг дамжуулан зээлийн авлагын тооцоо нийлсэн акттай 5,084.9 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл хэрэгжүүлэгч нэгж нь анхан шатны баримтын бүрдэл дутуу 323.1 сая төгрөг, үндсэн хөрөнгө, бараа материал 47.9 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлаас бэлтгэж зориулалт бус зардал гаргасан байна. Эдгээр нь:

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 26.6-д "ТХН нь төслийн эцсийн тайланг журмын энэхүү 12 дугаар Хавсралтын дагуу боловсруулж, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлнэ";

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Авлага өр, төлбөр үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, төсвийн зарцуулалтанд тавих хяналт сул, хууль, журам мөрдөгдөхгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дууссан төслийн хаалтын санхүүгийн тайлан гарган хөрөнгө эх үүсвэрийг хууль, журмын дагуу шилжүүлж ажиллаж байх, төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж үр дүнг тайлагнах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Харьяа газруудын илэрсэн зөрчилтэй холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 8 төсөл, хөтөлбөр нэгж, ТЕГ-ын харьяа Багахангай дүүргийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 161,448.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 105,883.5 сая төгрөгийн 83 алдааг залруулж, 191.1 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 438.5 сая төгрөгийн зөрчилд 36 албан шаардлага, 54,935.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 173 зөвлөмж өглөө.

3.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагууд болон төсөл, хөтөлбөрийн дамжуулан зээлийн авлага, өр төлбөрийг санхүүгийн тайланд бүртгэх, тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах, төслийн нэгжүүдийн зарцуулалт, бүртгэл тайлагналыг сайжруулах, санхүүгийн бодлогоор хангаж ажиллах, үр дүнг дүгнэх.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "...санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу арга хэмжээ авч ажиллаж, биелэлтийг 2020 оны 08 дугаар сарын 1-ний дотор ирүүлэх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 8 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,572,707,720.8	6,130,857,980.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,128,532,099.1	1,782,740,778.4
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	529,812,995.8	728,105,139.4
33	АВЛАГА	1,478,164,764.5	1,668,131,339.7
34	УРЬДЧИЛГАА	17,896,810.4	104,708,012.8
35	БАРАА МАТЕРИАЛ	19,123,112.4	9,831,594.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	399,177,938.5	1,837,341,116.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,354,006,453.5	5,394,208,100.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	3,949,787,942.5	4,568,783,922.3
37100	Урт хугацаат хадгаламж	54,991,407.2	60,117,028.8
37200	Үнэт цаас	410,788,972.5	424,941,992.0
37300	Урт хугацаат зээл	3,484,007,562.8	4,083,724,901.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	404,218,511.0	825,424,178.1
39200	Биет хөрөнгө	275,281,643.9	691,105,445.6
39300	Биет бус хөрөнгө	16,842,075.3	15,322,737.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	112,094,791.8	118,995,994.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,926,714,174.3	11,525,066,081.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,986,744,733.1	6,872,011,359.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,464,694,214.5	1,470,582,726.5
41100	Богино хугацаат үнэт цаас	61,679,526.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,282,300,447.5	1,256,833,828.2
41300	Өглөг	83,197,696.5	154,462,318.6
41400	Урьдчилж орсон орлого	37,516,544.6	59,286,579.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,522,050,518.5	5,401,428,632.7
42100	Урт хугацаат үнэт цаас	2,329,781,643.1	2,173,068,797.3
42200	Урт хугацаат зээл	3,192,268,875.5	3,228,359,835.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,939,969,441.2	4,653,054,722.2
51	Засгийн газрын хувь оролцоо	1,939,969,441.2	4,653,054,722.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	103,132,073.6	105,127,805.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,341,766,933.9	1,362,382,139.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	38,130,593.6	43,130,593.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	110,108,422.2	106,456,751.2
51200	Хуримтлагдсан үр дүн	290,392,919.4	2,956,398,123.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,438,498.6	59,907,863.5
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	651,445.9
51600	Нөөцийн сан	0.0	19,000,000.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,926,714,174.3	11,525,066,081.4

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,309,589,765.5	4,642,706,797.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	795,592,962.2	982,076,589.0
110	Орлогын албан татвар	330,208,484.2	412,319,046.7
1103	ААН-ын орлогын албан татвар	69,240,864.9	40,430,278.9
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	260,967,619.4	371,888,767.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	465,384,477.9	569,757,542.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	879,275,329.5	2,342,396,113.3
120	Нийтлэг татварын бус орлого	873,295,865.5	2,251,578,684.3
122	Тусламжийн орлого	3,320,611.3	87,598,789.2
124	Зээлийн орлого	2,658,852.7	3,218,639.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,634,721,473.9	1,318,234,095.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,428,276,302.9	2,445,867,106.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,411,190,559.5	2,444,267,065.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,114,438.8	504,022,241.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,946,343.8	112,952,040.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,445,353.2	14,473,110.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,908,664.8	8,884,033.3
2104	Хангамж, бараа материалын зардал	9,031,366.3	10,770,235.2
2105	Нормативт зардал	297,769.0	534,098.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,556,472.3	3,101,379.6
2107	Томилолт, зочны зардал	3,404,983.5	4,119,484.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,404,692.2	262,930,814.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,118,793.7	86,257,045.9
211	ХҮҮ	1,512,605,012.1	1,208,200,075.8
212	ТАТААС	-	9,782,820.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	523,471,108.6	722,261,927.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,085,743.4	1,600,041.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	881,313,462.7	2,196,839,690.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	86,794,903.1	54,408,274.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	191,367,740.0	733,172,559.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	776,740,625.8	1,518,075,405.9

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,779,151,130.7	4,711,982,079.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	775,203,549.4	900,926,103.0
110	Орлогын албан татвар	324,428,630.7	371,401,865.8
1103	ААН-ын орлогын албан татвар	69,240,864.9	40,430,278.9
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	255,187,765.8	330,971,586.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	450,774,918.8	529,524,237.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	450,774,918.8	529,524,237.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,259,319,482.7	2,187,429,140.9
120	Нийтлэг татварын бус орлого	3,254,078,596.1	2,159,695,523.0
122	Тусламжийн орлого	5,240,886.6	27,733,617.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,744,628,098.6	1,623,626,835.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,372,518,530.0	4,379,394,885.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,372,518,530.0	4,379,394,885.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,937,391,406.0	1,772,813,806.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,288,544.1	110,403,634.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,369,453.2	15,858,832.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,055,641.6	8,469,828.1
2104	Хангамж, бараа материалын зардал	48,015,398.5	11,008,156.2
2105	Нормативт зардал	197,073.4	2,150,303.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,193,940.9	4,774,721.1
2107	Томилолт, зочны зардал	3,119,325.0	3,795,968.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,558,017,005.1	692,198,954.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203,135,024.2	924,153,407.4
211	ХҮҮ	1,405,544,236.3	1,269,961,109.5
212	ТАТААС	-	9,782,820.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,029,582,887.8	1,326,837,149.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	406,632,600.7	332,587,194.4
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	56,119,979.0	309,814,241.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	77,896,945.7	928,101,637.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,896,945.7	928,101,637.5
2200	Дотоод эх үүсвэрээр	77,896,945.7	928,101,637.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(21,776,966.8)	(618,287,395.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	436,135,909.4	(60,091,119.5)
14	Бусад эх үүсвэр	1,477,348,695.7	373,283,142.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	164,149,305.2	193,620,770.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	877,063,481.1	239,753,492.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	820,991,543.4	(345,791,320.8)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,307,540,555.8	2,128,532,099.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,128,532,099.1	1,782,740,778.4

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,183,132,366.1	-	1,183,132,366.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(8,635,185.1)	-	(8,635,185.1)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,174,497,181.0	-	1,174,497,181.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	28,732,504.7	-	28,732,504.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	5,522,189.9	-	5,522,189.9
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(52,012,532.7)	-	(52,012,532.7)
7	Өмчид гарсан өөрчилөлт	6,602,143.4	-	6,602,143.4
8	Зарласан ногдол ашиг	(115,573.4)	-	(115,573.4)
9	Тайлант үеийн үр дүн	776,740,625.8	-	776,740,625.8
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,939,969,441.2	-	1,939,969,441.2
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,939,969,441.2	-	1,939,969,441.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,128,680,674.2	-	1,128,680,674.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,068,647,213.0	-	3,068,647,213.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	362,757.9	-	362,757.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,992,343.0	-	4,992,343.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	71,471,466.5	-	71,471,466.5
18	Зарласан ногдол ашиг	(10,494,489.9)	-	(10,494,489.9)
19	Тайлант үеийн үр дүн	1,518,075,405.9	-	1,518,075,405.9
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,653,054,722.2	-	4,653,054,722.2

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,692,976,610.4	2,736,220,039.3	-43,243,428.9	101.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,498,205,729.8	1,439,102,443.1	59,103,286.7	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,234,681.6	264,880,684.2	47,353,997.4	84.8
